



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/05

Булган сум

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд малын гоц халдварт хонины цэцэг, бог малын мялзан өвчний шинэ халдварын тохиолдол бүртгэгдэж, аймгийн хэмжээнд Баян-Агт, Сайхан, Орхон суманд хорио цээрийн дэглэм хэрэгжиж байгаатай холбогдуулан уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

1.1. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед ажиллах мэргэжлийн багийг томилж, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах,

1.2. Малын гоц халдварт өвчний талаар МЭЕГ-аас гарсан зөвлөмж, анимейшн болон үр дагаварын талаар малчдад заавар, зөвлөгөө, зөвлөмжийг тогтмол өгөх.

1.3. Малчидтай хариуцлагын гэрээ байгуулах ажлыг холбогдох байгууллага, албан тушаалтантай хамтран зохион байгуулах,

1.4. Малын гоц халдварт өвчний асуудлыг бүрэн хяналтанд авах хүртэл амьд мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, отор нүүдлийн маршрутыг тогтоох,

1.5. Сум орон нутгийн түвшинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд шаардагдах төсөв, зардлыг оновчтой төлөвлөж, теникийн болон хүн хүчний нөөцийг бүрдүүлэх,

1.6. Малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл, өвчний нөхцөл байдлын мэдээ мэдээллийг хөрш зэргэлдээ аймаг сумдын түвшинд тогтмол мэдээлж, хамтран ажиллах,

1.7. Мал, амьтны халдварт өвчин гарсан хот аймлын өтөг бууц, хашаа хороо, устгалын цэгт халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх,

2. Хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт "Мэргэжлийн баг" томилон тандалт судалгааны ажлыг эрчимтэй зохион байгуулахыг Баян-Агт, Сайхан, Орхон сумын Засаг дарга нарт, удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), голомтын болон сэжигтэй бүсээс гадагш хүн, мал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), шуурхай бүлэгт дэмжлэг үзүүлж хамтарч ажиллахыг Тагнуулын хэлтэс (хурандаа Б.Жавхлантөгс) нарт тус тус үүрэг болгосугай.

Сугар Ажил 2023 өдөр бүр Дос/2023/Захирамж

6322011126

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган, үүрэг чиглэл өгч ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ш.Баасандорж), аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн (Д.Алтаншагай) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ